

БИНДЭР СУМЫН СДЭ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Ч. Эрдэнэбаатар
Утас: 70562112
Цахимхаяг:

Аудитын менежер:
Д. Оюунтуяа
Утас: 70562147
Цахимхаяг:

Аудитор:
Утас:
Цахимхаяг:

ТАБ-ын хаяг: Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газар
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн сум
Сариг баг
Цахим хуудас: www.audit.mn

Өнлөрхаан Итгэл Аудит ХХК
Захирал Б.Маналсүрэн
Утас 70562575, 99059424
Цахим хаяг:
undurkhaanitgel@yahoo.com

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Биндэр сумын СДЭ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ХЭА-2018/32/СТА-ХАК-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Биндэр сумын СДЭ-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Биндэр сумын СДЭ-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 07-ноос 2018 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн Аймгийн аудитын газрын гэрээт Өндөрхаан Итгэл Аудит ХХК-ийн 1 дүгээр багийн аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Биндэр сумын СДЭ нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 14-нд Өндөрхаан Итгэл Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Өндөрхаан Итгэл Аудит ХХК нь аудитыг 2018 оны 2 дугаар сарын 15-наас 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 25-нд Биндэр сумын СДЭ-ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Биндэр сумын СДЭ-ийн төсвийн захирагч нь “Эрүүл мэндийн тухай” Монгол улсын “Төсвийн тухай” “Нягтлан бодох бүртгэлийн тухай” “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” “Хөдөлмөрийн тухай” “Төрийн аудитын тухай” “Нийгмийн даатгалын тухай” “ХХОАТ-ын тухай” “Шилэн дансны тухай” хуулиуд болон Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 1 дүгээр зүйл 1.1-д “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтаны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэсэн заалтыг баримтлан ажилладаг.

Нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, эмийн зохистой хэрэглээг ард иргэдэд мэдээлэх, багийн эмчийн нийгмийн асуудалд анхаарах, удирдлагын менежментийг боловсронгуй болгож, мэргэжлийн чадавхийг сайжруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын түвшинд хүргэж үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулах зэрэг үйл ажиллагаанд энэ байгууллагын зорилт оршиж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга /захирал, эрхлэгч/ тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Биндэр сумын СДЭ-ийн эрхлэгч нь төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Биндэр сумын СДЭ-ийн 2017 оны төсвийг Аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой. Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Бусад хууль тогтоомжуудыг байгууллагын эрх зүйн орчин хэсэгт харуулав.

Биндэр сумын СДЭ-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Биндэр сумын СДЭ-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 6-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Биндэр сумын СДЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан салбарын сайдын А/02 тушаалаар батлуулан 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү

бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Биндэр сумын СДЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Биндэр сумын СДЭ-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүү нягтлан бодох бүртгэлийн СТС санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. Энэхүү программ нь үндсэн хөрөнгийн элэгдэл бодоход хүндрэлтэй, СБТайланд бараа материал дутуу тайлагнадаг, мөнгөн хөрөнгийн журналаас худалдан авсан үндсэн хөрөнгийн дүн МГТайланд татагддаггүй. Иймээс санхүүгийн үндсэн тайлангуудад гараар засвар хийдэг дутагдалтай талууд ажиглагдсан.

Материаллаг байдлын түвшин:

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 1 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 4,5 сая төгрөг гэж тооцов.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Биндэр сумын СДЭ-ийн хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан аймгийн Төрийн сангаас санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Биндэр сумын СДЭ-ийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 386506,1 мянган төгрөгийн санхүүжилт, нэмэлтээр 11448,9 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 23439,9 мянган төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал зардалд 412956,1 мянган төгрөг батлагдсанаас 412404,3 мянган төгрөгийг зарцуулж 551,8 мянган төгрөг хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны хуулийн гол зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үр ашигтай зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод нээлттэй, ойлгомжтой байх түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэж заасан.

Биндэр сумын СДЭ-ийн шилэн дансанд байгууллагын батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, санхүүжүүлэх эх үүсвэрийн 1-12 дугаар сарын мэдээг шивж оруулсан байна. 5

сая төгрөгнөөс дээш дүнтэй орлого, төсөв хөрөнгөтэй холбогдолтой тушаал шийдвэрийг шилэн дансанд мэдээлсэн байна. 6,7,8 дугаар саруудад мэдээллийн хугацааг хоцроосон байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж хавсаргав.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 20 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 20 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Сургалт хөтөлбөрийн зардалд зарцуулсан бараа материалыг орлогод авалгүй шууд зардалд бичсэн. 1 ажилтны цалингаас дутуу суутгасныг авлагаар бүртгээгүй, сургалт хөтөлбөрийн зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн, НДШийн зардлаас цалин олгосон, ХХОАТ төлсөн, цалингийн зардлаас шагнал олгосон зэрэг зөрчлүүд гарсан нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал, толилуулга ба илчлэл гэсэн батламж мэдэгдлийн шаардлагыг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Биндэр сумын СДЭ-ийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, цалин, НДШ, ХХОАТ, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, зардал, авлага өглөг зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Ажиллагсадын цалингаас 928.1 мянган төгрөгийн НДШ дутуу тайлагнасанаас 194.8 мянган төгрөгийн НДШ төлөөгүй, 1 ажилтны 15.6 мянган төгрөгийн НДШ дутуу суутгасан нь НД-ын тухай Хуулийн 17 дугаар зүйлийн 1 " Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 17 дугаар зүйлийн 1.1 дэх заалт "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

2. Ажилтны цалингаас 107,8 мянган төгрөгийг дутуу суутгасныг авлагаар бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 13.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилд төлбөрийн акт тогтоох

3. Сургалт хөтөлбөрийн зардалд зарцуулсан 2416,6 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардалд бүртгэсэн нь Монгол улсын Сангийн сайдын 2000 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн тушаалаар баталсан "Эд

хариуцагчийн эрх үүргийн дүрэм"-ийн 2.9-д "Мөнгөн хөрөнгө, бараа материалын үнэт зүйлийг хүлээн авах, тавьж олгох, борлуулах ажлыг дагалдах баримт хуваарь, лимит зэргийг харгалзан өөрийн биеэр заавал шалган тоолж гүйцэтгэх ба орлого зарлагын баримт, анхан шатны бүртгэлийн заавар, баримт бичилтийн дүрмийн шаардлагын дагуу цаг тухайд нь цэвэр нямбай, засваргүйгээр үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна" 2.10-д "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна" гэж заасныг тус тус зөрчиж байна..

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

4. Цалингийн зардлаас 100,0 мянган төгрөгийн шагнал олгосон, НДШ-ийн зардлаас 834,4 мянган төгрөгийн цалин олгосон, татвар төлсөн, Нийгмийн эрүүл мэнд сургалт сурталчилгааны зардлаас 198,3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Монгол улсын Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Тус байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 3867,5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба материаллаг бус 4 алдааг санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй тул залруулах шаардлагагүй гэж үзлээ.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Биндэр сумын СДЭ-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад яригдсан асуудлууд болон менежментийн захидлаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянан үзнэ.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Биндэр сумын СДЭ-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3867,5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 107,8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 3759,7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөхөөр тогтов.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Биндэр сумын СДЭ-ийн 2016 оны санхүүгийн тайланд аудит тус Аймгийн Аудитын газар аудит хийж 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага өгөгдсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт


Биндэр сумын СДЭ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан, менежментийн захидал, аудитын гэрчилгээг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ОЮУНТУЯА

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

2317144307
СЮА0046 9074082

Б.МАНАЛСҮРЭН

2018.02.25



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.02.28 № 06/58
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Биндэр сумын Сум дундын эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Биндэр сумын Сум дундын эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Биндэр сумын Сум дундын эмнэлгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Биндэр сумын Сум дундын эмнэлэг нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

0500532

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

БИНДЭР СУМЫН СДЭ-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Цалин
Асуудал 2
Бараа материал
Асуудал 3
Зардал

2018 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Биндэр сумын СДЭ-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Биндэр сумын СДЭ-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал1: Цалин
Ажиглалт 1

Ажиллагсадын цалингаас 928.1 мянган төгрөгийн НДШ дутуу тайлагнаснаас 194.8 мянган төгрөгийн НДШ төлөөгүй, 1 ажилтны 15.6 мянган төгрөгийн НДШ дутуу суутгасан. Энэ нь НД-ын тухай хуулийн 17 дугаар зүйл болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №1

Зөвлөмж

НД-ын тухай Хуулийн 17 дугаар зүйлийн 1 "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 17 дугаар зүйлийн 1.1 дэх заалт "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заалтыг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг зөрчих эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Асуудал2: Бараа материал

Ажиглалт 2

Сургалт хөтөлбөрт зарцуулсан 2416,6 мянган төгрөгийн бараа материалыг орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн. Энэ Монгол улсын Сангийн сайдын 2000 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн тушаалболон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг зөрчих эрсдэлтэй

Тэргүүлэх ач холбогдол №1

Зөвлөмж

Монгол улсын Сангийн сайдын 2000 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн тушаалаар баталсан "Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм"-ийн 2.9-д "Мөнгөн хөрөнгө, бараа материалын үнэт зүйлийг хүлээн авах, тавьж олгох, борлуулах ажлыг дагалдах баримт хуваарь, лимит зэргийг харгалзан өөрийн биеэр заавал шалган тоолж гүйцэтгэх ба орлого зарлагын баримт, анхан шатны бүртгэлийн заавар, баримт бичилтийн дүрмийн шаардлагын дагуу цаг тухайд нь цэвэр нямбай, засваргүйгээр үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна", 2.10-д "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна" гэж заасныг тус тус мөрдөж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Асуудал 3: Зардал

Ажиглалт 3

- Цалингийн зардлаас 100.0 мянган төгрөгийн шагнал олгосон
- НДШ-ийн зардлаас 834,4 мянган төгрөгийн цалин олгосон, татвар төлсөн
- Нийгмийн эрүүл мэнд сургалт сурталчилгааны зардлаас 198,3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйл болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №1

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Монгол улсын Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар” Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг тус тус мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг зөрчих эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу


Бэлтгэсэн:

Аудитор

Хянасан:

Тэргүүлэх аудитор

Аудитын менежер



Б.Маналсүрэн

Ч.Эрдэнэбаатар

Д.Оюунтуяа